Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

2023 он

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#12
(21)

Сар тутмын хэвлэл

http://www.mnier.mn

XI сар

2023 оны тайлангийн хурлын нээлт (Нүүр 1-3)

Судалгаа, ЭШ-ний ажлын тайлан (Нүүр 3-7)

Үйл явдал, мэдээ Нүүр (7-8)

## Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн 2023 оны тайлангийн хурлын нээлт. Захирал М.Итгэл (доктор)

Боловсролын хүрээлэнгийн 2018 - 2022 оны стратеги төлөвлөгөө. Боловсролын судалгаагаар олон улсын түвшинд хүрсэн эрдэм шинжилгээ, арга зүйн тэргүүлэгч байгууллага байна.




Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн 2023 - 2027 оны стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж эхлэх.



## 1. МОНГОЛ СУРАЛЦАГЧИЙН 2030







## "МОНГОЛ СУРАЛЦАГЧ 2030"-ийн ШИНЖ БА ЧАДАМЖ







## 2023 ОНД ЗАХИРЛЫН МАНЛАЙЛЛААР ХИЙСЭН ОНЦЛОХ 5 АЖИЛ

| | | | |
|---|---|---|---|
| 1 | БСҮХ-ийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж эхлэх | **100%** | Захирлын тушаалаар батлав. |
| 2 | Монгол улсын боловсролыг 2030 хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал | **100%** | Эрдмийн зөвлөлөөр сайшаав. |
| 3 | "Монгол суралцагч 2030" | **100%** | Эрдмийн зөвлөлөөр дэмжив. |
| 4 | СӨБ болон ЕБ-ын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал | **90%** | СӨБ ба ЕБ мэргэжлийн зөвлөлөөр дэмжив. |
| 5 | Боловсролын судалгааны Монголын сэтгүүлийн 5 жилийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | **50%** | Төлөвлөгөөний төсөл |

## Судалгаа, эрдэм шинжилгээний ажлын тайлан
## Эрдэмтэн нарийн бичгийн дарга С.Санжаабадам

| ҮР ДҮНГИЙН БИЕЛЭЛТ Чиглэл | Чиг үүргийн дагуух үйл ажиллагаа | Үйл ажиллагаа тоогоор | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | Судалгааны чиглэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх | 18 | **99.4%** |
| | Арга зүйн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 23 | **100%** |
| Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | 22 | **99.5%** |

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТИЙН ХУВЬ




## ТӨЛӨВЛӨСӨН ОНЦЛОХ СУДАЛГАА

| Онцлох судалгаа | Биелэлтийн байдал |
|---|---|
| ЕБС-ийн математик суралцахуйг дэмжих Eduten платформыг турших судалгаа | Үндэсний хэмжээнд нэвтрүүлж байна. |
| Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлогийн судалгаа | Боловсруулалт |
| Ерөнхий боловсролын түвшинд хэрэглэж буй цахим сургалтын сан, платформын хэрэглээ, хүртээмжийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа | Боловсруулалт |
| Сургуулийн өмнөх боловсролын “Амьдралын мод” туршилтын судалгаа | Үндэсний хэмжээнд нэвтрүүлж байна. |
| Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгж өртгийн тооцоолол судалгаа | Хэлэлцүүлэг, бодлогын гарч |
| ЕБС-ийн 1 дүгээр ангид цагаан толгойн үсэг таниулах, уншуулж сургах арга зүйн туршилт, судалгаа | Хэлэлцүүлэг |
| “Бага ангийн багш бэлтгэх их, дээд сургуулийн жишиг хөтөлбөр боловсруулах | Тайлан гарсан |

## ТӨЛӨВЛӨСӨН ОНЦЛОХ СУДАЛГАА (үргэлжлэл)

| Онцлох судалгаа | Биелэлтийн байдал |
|---|---|
| Хүүхдийн академик үгийн нөөцийг тогтоож, түвшинд оноох | Боловсруулалт |
| Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг тогтоох турших судалгаа | Үр дүн гарсан |
| "Үндэсний бичиг" аппликейшны хөгжүүлэлт хийх (Эксперт, видео хичээл боловсруулах, танилцуулга видео хийх, туршилт хийх) | Сайжруулалт |
| Английн PEARSON олон улсын байгууллагын англи хэлний цогц сургалтын хөтөлбөрийг турших судалгаа | Үндэсний хэмжээнд нэвтэрч байна. |
| Бага боловсролын монгол хэлний сургалтын эхийн сан бүрдүүлэх судалгаа | Тайлан гарсан |
| Монгол улсад "Ахлах сургуулийг хөгжүүлэх чиглэл"-ийн төсөл боловсруулах (1.1.16) | Хэлэлцүүлэг |
| **Боловсруулалт хийгдэж буй** | **3** |
| **Хэлэлцүүлгийн түшинд** | **4** |
| **Үндэсний хэмжээнд үр дүн нэвтэрч буй/үр дүн тайлангийн түвшинд гарсан** | **6** |

## ТӨЛӨВЛӨӨГҮЙ ОНЦЛОХ СУДАЛГАА

| Онцлох судалгаа | Зарцуулсан хүн хоног |
|---|---|
| Хилийн чанад дахь "Монгол хэл, соёлын сургалтын байгууллага"-ын үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгаа | **30** |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд насан туршийн боловсролын төв, нэгжийн оруулж буй үүрэг, оролцоо | **30/2** |
| Боловсролын салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийн судалгаа | **3/5** |
| Дотуур байрны нөхцөл байдлын судалгаа | **14/47<br>30/6** |
| СӨБ болон ЕБС-ийн удирдах ажилтны чиг үүргийг тодорхойлох судалгаа | **10/6** |
| Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох түүвэр судалгаа | **12/11, 7/3, 4/5, 5/10, 2/10** |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтийн судалгаа | **3/10** |
| Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчин | **3/20** |
| Хувьсах зардлын норм нормативыг шинэчлэн тогтоох судалгаа | **3/56** |
| ЮНЕСКО Шанхай ФИТ – Багшийн стандарт, цогц чадамжийн хүрээ боловсруулах | **3/15** |
| Удирдах ажилтны чиг үүргийн судалгаа | **7/14** |
| **Онцолсон 11 судалгаа** | **1907/116** |

## ОНЦЛОГ, ҮР ДҮН

**Шинэ мэдлэг бүтээсэн (аргазүй, үзэл баримтлал)**

**Шинэ арга (test&method) бий болгосон**

**Шинэ технологи (LMS), арга зүй туршсан**

## ТӨЛӨВЛӨСӨН АРГА ЗҮЙН ОНЦЛОХ АЖИЛ

| Онцлох ажил | Биелэлтийн байдал |
|---|---|
| Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах | Хэлэлцүүлж байна. |
| Хувьсаж буй боловсрол- Монгол улсын амлалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, замын зураглал боловсруулах | Үр дүн гарсан |
| Хөтөлбөрийн хэрэгжилтийн зөвлөмж боловсруулах | Үр дүн гарсан |
| Насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрийн төсөл | хэлэлцүүлэх |
| Хос хэлний боловсролын талаар баримтлах чиглэлийн төсөл | хэлэлцүүлэх |
| МХХТ-ийн чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлох | хэлэлцүүлэх |
| Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан багшлахуй, суралцахуйг дэмжих зөвлөмж боловсруулах | Үр дүн гарсан |
| Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн зөвлөмжийг боловсруулах | Үр дүн гарсан |
| ЕБ-ийн бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах агуулга, арга зүй, хэл найруулга, дизайны шаардлагыг хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн шалгуур, үзүүлэлтийг боловсруулах | Үр дүн гарсан |
| 1-12 дугаар ангийн сурах бичгийг цахимд хэлбэрт шилжүүлэхэд БМТТ-тэй хамтран ажиллана. | Боловсруулалтын шатанд |
| Төрөлжсөн ахлах сургуулийг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийн төсөл боловсруулах | хэлэлцүүлэх |
| Ерөнхий боловсролын багшийн ажил мэргэжлийн стандартад дүн шинжилгээ хийх | Тайлан гарсан |
| **Боловсруулалт хийгдэж буй** | **1** |
| **Хэлэлцүүлгийн түшинд** | **5** |
| **Үр дүн тайлангийн түвшинд гарсан** | **6** |

## ТӨЛӨВЛӨӨГҮЙ АРГА ЗҮЙН ОНЦЛОХ АЖИЛ

| Онцлох ажил | Зарцуулсан хүн хоног |
|---|---|
| Хилийн чанад дахь сүм, хийдэд шавилж буй лам хүүхэд, залуучуудын боловсролын асуудлыг судлах | **10/1** |
| Сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмжийг боловсруулах түгээн дэлгэрүүлэх сургалт | **90/10** |
| ЕБС-ийн бага, дунд ангийн залгамж холбоог сайжруулах, дунд ангид дэвшин суралцаж буй сурагчийн дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зөвлөмж | **50/5** |
| Цэцэрлэгийн багш, багшийн туслах, арга зүйчийн ажил мэргэжлийн стандарт боловсруулах | **60/7** |
| Англи хэлний чиглэлээрх 24 ажил | **143/1** |
| Хүүхдийн хөгжлийн чиглэлээр 3 ажил | **20/3** |
| Хөтөлбөр 25 ажил | **2/30** |
| Сургуулийн өмнөх боловсролын багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглах хүүхдийн чадварыг илрүүлэх дасгал даалгавар | **10/1** |
| Тува хэлний зөв бичих дүрэм боловсруулах | **150/1** |
| ЕБС-ийн захирлуудын ур чадварыг тодорхойлох тест боловсруулах | **15/20** |
| 34 АЖИЛ | **3143/93** |

## 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГУУД

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**
- Боловсролын бодлого, төлөвлөлт
- Хувьсаж буй боловсрол хэлэлцүүлэг
- **Удирдах ажилтны сургалт**

**ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГА**
- АХБ
- Дэлхийн банк- боловсролын чанарын шинэчлэл
- НҮБ-ХИС, ХХ
- ТХ – II төсөл

**БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР**
- Сургуулийн менежмент, Суралцагч бүрийн суралцахуйг дэмжихэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

**ИРГЭНИЙ НИЙГЭМ, ТББ**
- Сургалт, аргазүйн чиглэлийн үйл ажиллагаан дээр хамтарсан, дэмжлэг үзүүлсэн.




**БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**
- Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагаа
- Бодлогын хэрэгжилтийг хангах, сургуулийн менежментийг дэмжих, сургуулийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, хүүхдийн хөгжлийн дэмжих

**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**
- Олон улсын судалгааны үр дүнг хуваалцах
- Гүйцэтгэлийн үнэлгээний арга хэрэгсэл боловсруулах, мэдээлэл цуглуулах

**СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА**
- Хүүхдийн хөгжлийн онцлогийг сургалтад ашиглах талаар сургалт/Цэцэрлэг, ЕБС/
- Багш, удирдах ажилтны судалгаа хийх ур чадварыг дэмжих сургалт/Цэцэрлэг, ЕБС/
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүй, цахим суралцахуйг дэмжих арга технологи /Цэцэрлэг, ЕБС/
- Цахим сургалтын байдал (МСҮТ, их, дээд сургууль)

**БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ**
- Дижитал сургалтын хэрэгжилтийг хангах

## ГОЛ БҮТЭЭЛ

### НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ, СУДАЛГААНЫ ТАЙЛАН

| | 2022 он | 2023 он |
|---|---|---|
| Нэг сэдэвт бүтээл | 2 | 3 |
| Судалгааны тайлан дотоодод | 15 | 12 |

### ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

| | 2022 он | 2023 он |
|---|---|---|
| Гадаадад | 15 / 50 | 4 / 39 |
| Дотоодод | 36 | 35 |

2022 он: Research Gate 15, Google Shcolar 50

2023 он: Research Gate 15+2, Google Shcolar 50+7

### ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

| | 2022 он | 2023 он |
|---|---|---|
| Гадаадад | 2 | 6 |
| Дотоодод | 30 | 8 |

## ХАМТАРСАН БАГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД ОРОЛЦОВ



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд, удирдлагууд, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын мэдээллийн технологийн төвийн төлөөллөөс бүрдсэн хамтарсан баг 2023 оны 12-р сарын 11-16-ны өдрүүдэд Бүгд найрамдах Финланд Улсад сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиглэлээр чадавхжуулах сургалтад хамрагдлаа.





Финландын Боловсролын үндэсний агентлаг (Finnish National Agency for Education), Финландын цахим сургалт, суралцахуйн инновацийн төв болон хөгжиж буй Eduten компани, дэлхийд алдартай Финландын Туркугийн их сургууль (University of Turku) зэрэг байгууллагууд тус чадавхжуулах сургалтыг хамтран зохион байгуулсан ба сургалтад оролцогчидтой Финландын боловсролын салбарын хөгжил дэвшил, олон улсын түвшний академик судалгаа шинжилгээний ажлууд болон сургалтын хөтөлбөрөө СӨБ, ЕБС-ийн түвшинд шинэчлэн боловсруулж амжилттай хэрэгжүүлж байгаа туршлагаасаа хуваалцаж хамтарсан хэлэлцүүлэг өрнүүлэв. Сургалтад оролцогчид Хэлсинк хотын сургууль цэцэрлэгийн цогцолборт зочилж үйл ажиллагаатай нь танилцлаа.

Мөн Финланд улсын Боловсрол, соёлын яамны зөвлөх Jouni Kangasniemi, Финландын Боловсролын үндэсний агентлагийн экспертүүд болон Турку ИС-ийн Суралцахуйн аналитикийн судалгааны хүрээлэн (Turku Research Institute for Learning Analytics)-ийн захирал, доктор Mikko-Jussi Laakso нарын тавьсан сонирхолтой илтгэлүүдийг сургалтад оролцогчид сонсож цаашид хамтран ажиллах, судалгааны төсөл хэрэгжүүлэх боломжуудын талаар ярилцсан. Финланд улс нь 1970-аад оноос боловсролын салбартаа далайцтай реформ хийж сургалтын хөтөлбөрийг үндэсний түвшинд нэгдмэл байдлаар болон орон нутгийн түвшинд өөрсдийн онцлогийг тусган хэрэгжүүлж боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулах, цэцэрлэг, сургуулиуд, багш нарыг чадавхжуулж сургалтын чанараа сайжруулах чиглэлд ихээхэн амжилтад хүрсэн улс юм.

БСҮХ-ийн захирал М.Итгэл, Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комланы хамт Хэлсинк хот дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Инновацийн газар (UNICEF Office of Innovation)-т зочилж үйл ажиллагаатай нь танилцах үеэр Монголын боловсролын системийн хөгжил, сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлалын талаар танилцуулж мэдээлэл солилцов. Монгол улсын боловсролын салбарын судалгаа шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн технологи хариуцан ажилладаг голлох төрийн байгууллагуудын ажилтнуудаас бүрдсэн энэхүү багт НҮБ-ын Хүүхдийн Сан санхүүгийн дэмжлэг үзүүлж Финланд улсад хамтарсан сургалтад оролцож мэдлэг, ур чадвараа ахиулах боломж олгосонд сургалтад оролцогчид талархлаа илэрхийллээ.

## БҮХ НИЙТИЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ




Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай” 372 дугаар тогтоолын хүрээнд зохион 2023 онд зохион байгуулагдсан үйл ажиллагаануудыг дүгнэх, багш сурагчид хоорондоо туршлага солилцох өдөрлөг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Тус өдөрлөгийг нээж БСҮХ-ийн захирал, доктор М.Итгэл үг хэлж, Энх тайвны корпусын сайн дурын ажилтан Даниел Линдбэрг болон ШУТИС-ийн англи хэлний зочин багш Скотт Потийт нар багш сурагчдад зориулан илтгэл хэлэлцүүллээ. Энэхүү арга хэмжээнд “Зөвлөгч сурагч”, “Велком”, “Бритиш сургуультай хамтарсан МРТ хөтөлбөр”-ийн 2022, 2023 оны оролцогчид хүрэлцэн ирж дараа жилийн ажлын талаар санал бодлоо хуваалцан, идэвхтэй оролцсон ба хэлэлцүүлгийг эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор С.Санжаабадам хааж үг хэллээ.